



МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ
ТОГТООЛ

2020 оны 5 сарын 25 өдөр

Дугаар 97

Улаанбаатар хот


Нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзах тухай

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг, Татварын ерөнхий газрын 2020 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 02/1722 тоот тодорхойлолтыг тус тус үндэслэн Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооноос ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн 11 дүгээр тойрогт “Та бидний эвсэл” /МАХН-ИЗНН-МУНН/-ээс нэр дэвшүүлсэн Агваан-Осорын Сүхбаатар нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.2-т заасан татварын хугацаа хэтэрсэн өр төлбөргүй байх шаардлагыг хангаагүй тул нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзсугай.

ДАРГА *Ч. Содном* Ч.СОДНОМЦЭРЭН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА *Ц. Болдсайхан* Ц.БОЛДСАЙХАН



000266